

### **Гурав. Магадлан итгэмжлүүлэх байгууллагад тавигдах шаардлага**

3.1 Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй эрүүл мэндийн байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрөлд заагдсан тусламж, үйлчилгээний төрөл бүрээр үйлчилгээг үзүүлдэг.
- 3.1.2 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заагдсан ажлын байрандаа сүүлийн нэг жилийн дотор үйл ажиллагаа явуулсан байх;
- 3.1.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан, зориулалтын байртай байх;
- 3.1.4 Тусгай зөвшөөрөлд заагдсан тусламж үйлчилгээг үзүүлэх эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан байх;
- 3.1.5 Жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байх, улирлын хугацаанд ажилладаг сувилал нь жилдээ 6 сараас доошгүй хугацаагаар ажилласан байх
- 3.1.6 Магадлан итгэмжлэлд орох асуудлыг хамт олноороо хүлээн зөвшөөрсөн байх
- 3.1.7 Магадлан итгэмжлэлд бэлтгэх зөвлөгөө авч, сургалтад хамрагдсан байх
- 3.1.8 Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх
- 3.1.9 Бүрдүүлсэн баримт бичгүүд үнэн, бодитой байх.

## **4.2 Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр:**

- 4.2.1 Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргахаас 12-24 сарын өмнөөс бэлтгэл ажлыг эхлүүлэх
- 4.2.2 Магадлан итгэмжлэлд бэлтгэх багийг зохион байгуулах, ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжүүлэх, магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг оролцоонд тунгуурлан хийж, тусламж, тулгамдсан асуудалд чиглэсэн чанар сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, дүгнэсэн
- 4.2.3 Байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээг зохицуулж буй тушаал, шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ хийн, хамт олны оролцоог ханган шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
- 4.2.4 Чанар, аюулгүй байдал, эрсдэл, оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж, дэвшилтэт технологи, арга аргачлал болон магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын чиглэлээр цахим болон ажлын байрны сургалтад хамрагдах
- 4.2.5 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ажлын албанаас ажлын байран дахь арга зүйн зөвлөгөөг авах, зөвлөмжийг хэрэгжүүлэх, дүгнэх
- 4.2.6 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлттэй уялдуулан өөрийн байгууллагын өвөрмөц үзүүлэлтийг тодорхойлон баталж, дүгнэлт хийх
- 4.2.7 Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хүрээнд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах
- 4.2.8 Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулсан, үр дүн гарсан байх

### **4.3 Магадлан итгэмжлэлийн дараах үе шат**

- 4.3.1 Магадлан итгэмжлэх шийдвэр гарснаас хойш 45-60 өдрийн дотор шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийг тусган тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр/төлөвлөгөөг боловсруулж, батлах;
- 4.3.2 Магадлан итгэмжлэгдсэнээ өөрийн байгууллагын цахим хуудсаар мэдээлэх;
- 4.3.3 Тусламж, үйлчилгээний чанарын хөтөлбөр /төлөвлөгөөг/ байгууллагын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх, жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дүгнэх;
- 4.3.4 Магадлан итгэмжлэлийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах, зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- 4.3.5 Хэрэв давтан магадлан итгэмжлэлд орох бол дараагийн магадлан итгэмжлэлд бэлтгэж, 4.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

### **5. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах, баримт бичиг бүрдүүлэх**

- 5.1 Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэлд орох бэлтгэлийг хаигасны дараа энэ журмын 5.3-т заасан баримт бичгийг бүрдүүлиэ.
- 5.2 Давтан магадлан итгэмжлэлд орох эрүүл мэндийн байгууллага нь батлашгийн хүчинтэй хугацаа дүүсахаас 90-зэс доошгүй хоногийн амне хүсэлтээ гаргасан

### **5.3 Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах байгууллага нь дараах баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлэн, баталгаажуулна.**

- 5.3.1 Магадлан итгэмжлүүлэх хүсэлт бүхий албан бичиг
- 5.3.2 Эрүүл мэндийн байгууллагын танилцуулга. /Батлагдсан маягтын дагуу магадлан итгэмжлэгдсэн хугацаанд тусламж, үйлчилгээнд гарсан ахиц, дэвшил, үйл ажиллагааны давуу, сул талыг тодорхойлон дүгнэлт хийсэн байх/
- 5.3.3 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
- 5.3.4 Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар /анх удаа орох байгууллагад хамаарахгүй/
- 5.3.5 Магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтээр хийсэн өөрийн үнэлгээний тайлан
- 5.3.6 Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр /төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
- 5.3.7 Тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ /давтан магадлан итгэмжлүүлэх байгууллага бол "Магадлан итгэмжлэгдсэн хугацааны, харин анх удаа магадлан итгэмжлүүлэх байгууллага бол сүүлийн 2 жилийн үзүүлэлт/
- 5.3.8 Үйлчлүүлэгчийн болон ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн дүн шинжилгээний тайлан /сүүлийн 2 жилийн үзүүлэлт/
- 5.3.9 Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн арга хэмжээний тайлан, дүгнэлт
- 5.3.10 Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлан
- 5.3.11 Магадлан итгэмжлэгдэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт
- 5.3.12 Эрүүл мэндийн байгууллага нь баримт бичгийг цаасан болон CD хэлбэрээр бүрдүүлж, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.